



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/ЮЧ

Мандалговь

“Тэнгэрийн тэмдэг” хүүхдийн жүжгийн уран  
бүтээлчдэд урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.10, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, аймгийн Засаг даргын 2017 оны А/251 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Урамшууллын жишиг тогтоох журам”-ын 1.4, 1.5, 1.7, 1.8, 3.2.1 дэх заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Тэнгэрийн тэмдэг” хүүхдийн театрын уран бүтээлчид “Гэгээн муза-15” Олон улсын театрын их наадмын “Хүүхдийн оролцоотой жүжгийн төрөл”-д “Тэнгэрийн тэмдэг” хүүхдийн жүжгээр амжилттай оролцож, Тэргүүн дээд шагнал Гран при хүртсэн тул тус жүжгийн уран бүтээлчдийг шагнаж урамшуулсугай.

2. Урамшууллын зардлыг хавсралтаар баталсугай.

3. Урамшуулалд олгох 3.000,000 (гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



481210286